



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/131/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi.audit.mn
Дорноговь аймаг
2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn
Аудитор: Л.Равдандорж
Цахим хаяг: Ravdandorjl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	12
3. Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	15
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Залруулсан алдаа.....	16
Аудитын зөвлөмж.....	17
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Эл. х. № 76/75
танай _____ -ны № _____ -т

САЙНШАНД ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
ДАРГА О.ЦЭЭНРЭГЗЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

440020478

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>65247086.81</u>	<u>85008507.05</u>
33	АВЛАГА	796833.76	1974150.00
335	Бусад авлага	796833.76	1974150.00
3351	Байгууллагаас авах авлага	158990.00	0.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	637843.76	1974150.00
35	БАРАА МАТЕРИАЛ	64450253.05	83034357.05
35300	Бэлэн бүтээгдэхүүн	29840617.88	0.00
354	Хангамжийн материал	29609635.17	74834357.05
35410	Бичиг хэргийн материал	4659447.00	5663627.40
35420	Аж ахуйн материал	20542257.17	66979325.65
35430	Сэлбэг хэрэгсэл	750000.00	750000.00
35440	Түлш, шатах тослох материал	3201600.00	0.00
35460	Хүнсний материал	456331.00	1441404.00
35600	Мал амьтад	5000000.00	8200000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2813359055.65</u>	<u>5977611863.46</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2813359055.65	5977611863.46
392	Биет хөрөнгө	2443699055.65	5505388130.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	2079682047.60	5485097072.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-201238286.25	-790623434.57
39203	Авто-тээврийн хэрэгсэл	308236017.00	308236017.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-163771196.78	-216157531.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	322995306.85	840676478.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-152850854.85	-186502899.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	97249195.40	130859587.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51377504.32	-66197158.78
39216	Дуусаагүй барилга, байгууламж	204774331.00	0.00
393	Биет бус хөрөнгө	369660000.00	472223733.00
39301	Программ хангамж	980000.00	71563733.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-936000.00	-980000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	369616000.00	401640000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2878606142.46</u>	<u>6062620370.51</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>9628274.59</u>	<u>1974150.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9628274.59	1974150.00
413	Өглөг	9628274.59	1974150.00
4136	Бусад өглөг	9628274.59	1974150.00
41361	Байгууллагад төлөх өглөг	9628274.59	1974150.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2868977867.87</u>	<u>6060646220.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2868977867.87	6060646220.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1293630053.34	1325654053.34
51101	Өмч: - төрийн	1293630053.34	1325654053.34
512	Хуримтлагдсан үр дүн	1181921213.93	4341565566.57

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	1181921213.93	1181921213.93
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	3159644352.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	393426600.60	393426600.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2878606142.46	6062620370.51

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2551900280.60	4281704747.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1600282780.60	3187672747.20
120	Нийтлэг татварын бус орлого	1600282780.60	3187672747.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2745000.00	6099000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2745000.00	6099000.00
120009	Бусад орлого	1597537780.60	3181573747.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	951617500.00	1094032000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	951617500.00	1094032000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951617500.00	1094032000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	924560097.57	1122060394.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	924560097.57	1122060394.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	901650234.09	1085599724.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	565932539.76	684348797.67
210101	Үндсэн цалин	550364539.76	395288096.71
210102	Нэмэгдэл	0.00	204605460.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15568000.00	18678000.00
210104	Урамшуулал	0.00	65777240.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71009847.95	86014858.08
210201	Тэтгэврийн даатгал	52576718.78	58833574.63
210202	Тэтгэмжийн даатгал	3729241.03	5531409.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	4577789.34	6730460.93
210204	Ажилгүйдлийн даатгал	970519.65	1458491.80
210205	Эрүүл мэндийн даатгал	9155579.15	13460921.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54813210.97	83957255.40
210301	Гэрэл, цахилгаан	18304800.07	28430427.40
210302	Түлш, халаалт	32552067.90	52579160.00
210303	Цэвэр, бохир ус	3956343.00	2947668.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29574734.40	36331465.50
210401	Бичиг хэрэг	7978391.00	7254693.60
210402	Тээвэр, шатахуун	15540600.00	16715000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	822500.00	1116474.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	953258.67	

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2412462.33	11245297.90
210408	Бараа материал акталсны зардал	1867522.40	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82177300.00	2734714.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	810970.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	1042114.00
210604	Урсгал засвар	81366330.00	1692600.00
2107	Томилолт, зочны зардал	1449000.00	2070000.00
210702	Дотоод албан томилолт	1449000.00	2070000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13529852.52	14590013.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5500335.00	5236510.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1008000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1920000.00	4020200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136000.00	131644.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100896.00	46178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	173500.00	178500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5699121.52	3968981.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83163748.49	175552620.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83088748.49	175552620.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22909863.48	36460670.02
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22909863.48	36460670.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22909863.48	36460670.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1627340183.03</u>	<u>3159644352.64</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	60706444.04	0.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	60706444.04	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-60706444.04	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1566633738.99</u>	<u>3159644352.64</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>957040798.00</u>	<u>1104235000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3879000.00	10203000.00
120	Нийтлэг татварын бус орлого	3879000.00	10203000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	99000.00	105000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	99000.00	105000.00
120005	Түрээсийн орлого	3780000.00	10098000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>953161798.00</u>	<u>1094032000.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	951617500.00	1094032000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	951617500.00	1094032000.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1544298.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1544298.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	841973143.00	959532073.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	841973143.00	959532073.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	816384981.52	918967402.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	566348488.52	683710953.76
210101	Үндсэн цалин	371926900.00	402706323.51
210102	Нэмэгдэл	115158636.85	190349698.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16864100.00	15889203.64
210104	Урамшуулал	62398851.67	74765728.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70747711.93	86383132.82
210201	Тэтгэврийн даатгал	53330311.93	67058302.95
210202	Тэтгэмжийн даатгал	4353800.00	4537387.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	3336740.60	3980114.90
210204	Ажилгүйдлийн даатгал	1018159.40	539900.20
210205	Эрүүл мэндийн даатгал	8708700.00	10267427.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49999963.07	89856665.40
210301	Гэрэл, цахилгаан	18540375.07	29549859.40
210302	Түлш, халаалт	27465388.00	53433398.00
210303	Цэвэр, бохир ус	3994200.00	6873408.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22980400.00	30608682.00
210401	Бичиг хэрэг	4500000.00	5027500.00
210402	Тээвэр, шатахуун	15540600.00	16715000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	822500.00	1225484.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	682600.00	607500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1434700.00	7033198.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	83881611.00	10425877.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1606406.00	1366050.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1084205.00	4028227.00
210604	Урсгал засвар	81191000.00	5031600.00
2107	Томилолт, зочны зардал	1449000.00	2070000.00
210702	Дотоод албан томилолт	1449000.00	2070000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20902807.00	15912092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14545735.00	6979590.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1008000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1920000.00	4020200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136000.00	131644.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	120896.00	46178.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	183500.00	178500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3996676.00	3547980.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75000.00	0.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25588161.48	40564670.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	1544298.00	0.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1544298.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22909863.48	36460670.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22909863.48	36460670.02
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1134000.00	4104000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1134000.00	4104000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>115067655.00</u>	<u>144702927.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	115067655.00	144702927.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	115067655.00	144702927.00
2200	Дотоод эх үүсвэрээр	115067655.00	144702927.00
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	115067655.00	144702927.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-115067655.00</u>	<u>-144702927.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>0.00</u>	<u>0.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /Төрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,351,674,038.04	335,382,615.90	-384,712,525.06	1,302,344,128.88
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,351,674,038.04	335,382,615.90	-384,712,525.06	1,302,344,128.88
C07	Тайлант үеийн үр дүн			1,566,633,738.99	1,566,633,738.99
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,293,630,053.34	393,426,600.60	1,181,921,213.93	2,868,977,867.87
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,293,630,053.34	393,426,600.60	2,748,554,952.92	

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	32,024,000.00	0.00	0.00	32,024,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,325,654,053.34	393,426,600.60	1,181,921,213.93	2,901,001,867.87
D08	Тайлант үеийн үр дүн			3,159,644,352.64	3,159,644,352.64
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,325,654,053.34	393,426,600.60	4,341,565,566.57	6,060,646,220.51

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хэтрэлт, хэмнэлт	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1096739300.00	1063670329.98	33068970.02	97.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1096739300.00	1063670329.98	33068970.02	97.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1096739300.00	1063670329.98	33068970.02	97.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	697333900.00	683710953.76	13622946.24	98.0
210101	Үндсэн цалин	410422800.00	402706323.51	7716476.49	98.1
210102	Нэмэгдэл	193515600.00	190349698.09	3165901.91	98.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	18595500.00	15889203.64	2706296.36	85.4
210104	Урамшуулал	74800000.00	74765728.52	34271.48	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93392100.00	86383132.82	7008967.18	92.5
210201	Тэтгэврийн даатгал	68490700.00	67058302.95	1432397.05	97.9
210202	Тэтгэмжийн даатгал	6225300.00	4537387.27	1687912.73	72.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	4980300.00	3980114.90	1000185.10	79.9
210204	Ажилгүйдлийн даатгал	1245100.00	539900.20	705199.80	43.4
210205	Эрүүл мэндийн даатгал	12450700.00	10267427.50	2183272.50	82.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97860000.00	89856665.40	8003334.60	91.8
210301	Гэрэл, цахилгаан	34574500.00	29549859.40	5024640.60	85.5
210302	Түлш, халаалт	54491300.00	53433398.00	1057902.00	98.1
210303	Цэвэр, бохир ус	8794200.00	6873408.00	1920792.00	78.2

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	30638400.00	30608682.00	29718.00	99.9
210401	Бичиг хэрэг	5027500.00	5027500.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	16717900.00	16715000.00	2900.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1236700.00	1225484.00	11216.00	99.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	610800.00	607500.00	3300.00	99.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7045500.00	7033198.00	12302.00	99.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	146373200.00	146128804.00	244396.00	99.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	21876900.00	21680530.00	196370.00	99.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4032700.00	4028227.00	4473.00	99.9
210604	Урсгал засвар	120463600.00	120420047.00	43553.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	2110400.00	2070000.00	40400.00	98.1
210702	Дотоод албан томилолт	2110400.00	2070000.00	40400.00	98.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28869800.00	24912092.00	3957708.00	86.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	19778800.00	15979590.00	3799210.00	80.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1008000.00	1008000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4020200.00	4020200.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	136000.00	131644.00	4356.00	96.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	140000.00	46178.00	93822.00	33.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	178900.00	178500.00	400.00	99.8
210807	Газрын төлбөр	28000.00	0.00	28000.00	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3579900.00	3547980.00	31920.00	99.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	161500.00	0.00	161500.00	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	161500.00	0.00	161500.00	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1096739300.00	1104235000.00	-7495700.00	100.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1096199300.00	1094032000.00	2167300.00	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1096199300.00	1094032000.00	2167300.00	99.8

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	540000.00	10203000.00	-9663000.00	1889. 4
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	540000.00	10203000.00	-9663000.00	1889. 4

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг О.Цэенрэгзэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зохих хууль журмын дагуу зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 04-өөс 2021 оны 02 дугаар сарын 09-ний хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Равдандорж хариуцаж хэрэгжүүлэв.

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/34 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Сайншанд дахь Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах
- Улсын төсөв бүрдүүлэх
- Гаалийн хяналт шалгалтыг хийх, зохион байгуулах
- Гаалийн бүрдүүлэлт хийх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлын 1,122,060.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,220.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сайншанд дахь Гаалийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,184,014.2 мянган төгрөгөөр буюу 210.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	796.8	1,974.2	1,177.3
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	64,450.3	83,034.4	18,584.1
Үндсэн хөрөнгө	2,813,359.1	5,977,611.9	3,164,252.8
Нийт хөрөнгө	2,878,606.1	6,062,620.4	3,184,014.2
Өр төлбөр	9,628.3	1,974.2	-7,654.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,868,977.9	6,060,646.2	3,191,668.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,878,606.1	6,062,620.4	3,184,014.2

Авлага дансны үлдэгдэл 1,974.2 мянган төгрөг болж 1,177.3 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх тайлант оны авлагыг бүрэн барагдуулсан боловч тайлант онд суутган төлөгчийн татварын суутгалаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэл нь тайлант онд үүссэн бөгөөд он удаан жил болсон авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 83,034.4 мянган төгрөг болж 18,584.1 мянган төгрөгөөр өссөн нь хяналт шалгалтад шаардлагатай багаж хэрэгсэл ГЕГ-аас хүлээн авснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материалын үлдэгдэл тусгагдаагүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,977,611.9 мянган төгрөг болж 3,164,252.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд теле хяналтын системийн тоног төхөөрөмж шинээр суурилуулсан мөн Ханги боомтын шалган нэвтрүүлэх цогцолборын барилга байгууламжийг шинээр бүртгэсэн шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 144,702.9 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3,068,359.2 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 239,120.34 мянган төгрөг, акталсан 13,054.88 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансны үлдэгдэл 401,640.0 мянган төгрөг болж 32,024.0 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь газар эзэмших гэрчилгээ гарсан 3 газрын эзэмших эрхийг бүртгэлд тусгаснаас шалтгаалжээ. Газар эзэмших эрхийн материалыг бүрэн хавсаргаж орлогод авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 1,974.2 мянган төгрөг болж 7,654.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны түлш халаалтын өглөгийг бүрэн барагдуулсан боловч суутган төлөгчийн төлөх татварын дүнгээр өглөг үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,060,646.2 мянган төгрөг болж 3,191,668.4 мянган төгрөгөөр өссөн нь эздийн өмч нэмэгдсэн шалтгаалжээ. Энэ нь тус газарт Гаалийн ерөнхий газраас теле хяналтын системийн тоног төхөөрөмж болон БНХАУ-ын Дархан муу мянган хошууны захиргаанаас буцалтгүй тусламжаар өгсөн барилга байгууламжийг бүртгэлд тусгасан мөн тайлант үеийн ашиг, элэгдэл хорогдол шалтгаалжээ.

Сайншанд дахь гаалийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,729,804.4 мянган төгрөгөөр буюу 167.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь тайлант онд БНХАУ болон ГЕГ-аас шилжүүлэн хөрөнгөөс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 197,500.3 мянган төгрөгөөр буюу 17.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал байна. Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор цалин нэмсэн мөн ажлын ачааллыг нэмэгдүүлсэн нь шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,096,739.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,096,739.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,096,739.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,096,199.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 540.0 мянган төгрөгийг төрийн өмчийн түрээсийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,057,571.3 мянган төгрөг, төрийн өмчийн түрээсийн орлогоос 10,203.0 мянган төгрөгийн эх үүсвэр төвлөрч урсгал үйл ажиллагаанд 1,067,774.3 мянган төгрөгийг зарцуулж 40,564.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,067,774.3 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байгаа нь тайлант оны үйл ажиллагааны хэмнэлттэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 11 мэдээлэл байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,242.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 29,840.6 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,242.0	1	1,242.0	-	-	100
Албан шаардлага	1		1		-	-	100
Зөвлөмж	1	29,840.6	1	29,840.6	-	-	100
Нийт дүн							

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 587,198.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 585,223.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4 алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материал худалдан авч шууд зардалд бичсэн 409.9 мянган төгрөгийн бичилтийн алдааг залруулсан.
2. Барилга байгууламжийн дансанд нийт 308,704.7 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн зам талбай, гэрэлтүүлэг, хашаа гэх мэт ... хөрөнгө бүртгэсэн байсныг залруулсан.
3. Тайлант оны үр дүнг 272481.7 мянган төгрөгөөр буруу илэрхийлсэн байсныг залруулсан.
4. Үндсэн хөрөнгийн дансанд тайлант онд 137.5 мянган төгрөгийн элэгдлийг бодуулаагүй байсныг залруулсан.
5. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 2,490.0 мянган төгрөгийн орлого, зардлыг тайлагнаагүй байсныг залруулсан.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Сайншанд дахь Гаалийн газрын хөрөнгийн бүртгэлд үндсэн хөрөнгийн шинжтэй худалдан авалтыг бүртгэж зарцуулах байдал ажиглагдаж байгаа тул хөрөнгийн ашиглалт, зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Хөрөнгийн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдэж дүүссэн боловч ашиглагдаж байгаа мөн данс бүртгэлд байгаа боловч ашиглагддаггүй хөрөнгө байна.
- 1.2. Эрсдэл: Хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг бодитой тооцож ажиллахгүй байгаа нь төсвийн үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчим алдагдахаар байна.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: "1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол 7 дугаар зүйл "хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 5 дугаар зүйл 5.1.5 "хэмжигдэхүйц байх" гэж тус тус заасан байдаг тул байгууллагын эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон ашиглалтад хууль, журамд заасны дагуу зохих арга хэмжээг авч ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Батлагдсан төсөв нь ТБОНӨХБАУ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн дүнгээс доош дүнтэй боловч гэрээ шүүд байгуулах нөхцөлд баримтлах шалгуурыг хангахгүйгээр худалдан авалтыг хийсэн байна.

- 2.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлтэй зарцуулахгүй байх.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", ТБОНХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйл 3.1-т "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө" 5 дугаар зүйл "34.2.Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шүүд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана" гэж тус тус заасан байдаг тул цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлтэй байхаар төлөвлөж зарцуулах.

- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

- 3.1 Илрүүлэлт: Хувь хүмүүстэй хийсэн худалдан авалтаас татварын суутгалыг хийж тайлагнаагүй байна.

- 3.2 Эрсдэл: Татварын хууль тогтоомжийг зөрчих.

- 3.3 Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Татварын ерөнхий хууль 6 дугаар зүйл 6.1.19."суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг; 28 дугаар зүйл 28.7.Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана. 83 дугаар зүйл 83.1.Суутгавал зохих татвараа суутгаагүй, эсхүл суутган авсан боловч төлж, тайлагнаагүй суутган төлөгч нь уг татварыг нөхөн төлөх үүрэгтэй. гэж тус тус заасан байдаг тул цаашид холбогдох хууль, журмыг мөрдөж татвар, хураамжийг суутган, тайлагнаж байх.

- 3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Хөрөнгийн хадгалалт хамгаалалттай холбоотой асуудал

- 4.1 Илрүүлэлт: Эд хөрөнгийн тооллогыг эд хариуцагч нэг бүрээр хийдэггүй байна.

- 4.3 Эрсдэл: Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт суларна.

4.3 Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.2. Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй: "1/ өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах; 2/ улсын төсвөөс олгосон хөрөнгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулж, тайлагнах", 71 дүгээр зүйл 71.1.2 –т "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдээдлийн бүртгэлтэй түлгэн шалгасан байх" гэж тус тус заасан байдаг тул байгууллагын эд хөрөнгийг эзэмшиж, ашиглаж байгаа хариуцагч бүрээр нь тоолж зохих журмын дагуу бүртгэл хөтлөн ажиллах.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			дга-2021/131/ста-тшз
Шалгагдсан байгууллагын нэр:	Сайншанд дахь Гаалийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бараа материал худалдан авч шууд зардалд бичсэн.	409.9	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
2	Барилга байгууламжийн дансанд нийтийн эзэмшлийн зам талбай, гэрэлтүүлэг, хашаа гэх мэт ... хөрөнгө бүртгэсэн.	308,704.7	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
3	Тайлант оны үр дүнг буруу илэрхийлсэн.	273,481.7	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
4	Үндсэн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй.	137.5	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
5	Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зардлыг тайлагнаагүй.	2,490.0	Залруулсан	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
6	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдэж дууссан боловч ашиглагдаж байгаа мөн данс бүртгэлд байгаа боловч ашиглагддаггүй хөрөнгө байна	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
7	Батлагдсан төсөв нь ТБОНӨХБАУ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн дүнгээс доош дүнтэй боловч гэрээ шууд байгуулах нөхцөлд баримтлах шалгуурыг хангахгүйгээр худалдан авалтыг хийсэн байна.	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
8	Хувь хүмүүстэй хийсэн худалдан авалтаас татварын суутгалыг хийж тайлагнаагүй байна.	1,974.2	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
9	Эд хөрөнгийн тооллогыг эд хариуцагч нэг бүрээр хийдэггүй байна.	0	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	О.Цэенрэгзэн, Б.Даваадулам
	ДҮН	587,198.0			